

Сяньбийн угсааны аймгууд, тэдний Монголчуудтай холбогдох нь

П.Дэлгэржаргал

МУИС-ийн Түүхийн тэнхмийн багш, доктор (Ph.D)

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд МЭ III-IV зууны үеийн Сяньбийн угсааны Тоба (Табгачи) – 拓跋 (tuoba), Цифү- 乞伏(Qifu), Түфа-禿發(Tufa), Жоужань- 柔然(rouran), Түгүхунь- 吐谷浑(Tuyuhun / tughun), Муюн- 慕容(murong), Күмоси- 库莫奚(Kumoxi), Хятан- 契丹(Qidan) аймгуудын угсаа гарвал, тэдний угсаа-түүхийн хөгжилд гүйцэтгэсэн үүргийг тодруулахыг зорилоо.

Түлхүүр үг: монгол угсааны аймгууд, угсаа гарвал, угсаатны адилсал, угсаа-соёлын хөгжил.

Төр ёс, угсаа-соёлын хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурь тодрон гарч ирж байна.

“Бүр II зууны эцэс гэхэд одоогийн Монголын нутагт Сяньбийн тавь гаруй аймаг оршин байсан” бөгөөд тэдгээр аймгуудын бүгдийнх нь нэр түүхэнд тэмдэглэгдэн үлдээгүй ч, Хятадын төрийн албан МЭ I зууны дунд үеэс сяньби аймгууд цэрэг-улс төрийн талаар ихээхэн бэхжин хүчирхэгжиж, Төв Азийн улс төрийн тавцанд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэх болжээ. Хүннү гүрэн дотоод зөрчилдөө автагдан задарч, хүч чадал нь суларч байхад Сяньбийн аймгууд улам бүр хүчирхэгжиж, байр суурь нь бэхжин, бие даах болсоноор барахгүй, Хүннүгийн эсрэг эвсэл байгуулан довтолж, аюул занал учруулах болжээ. Энэ үед сяньби нь харьцангуй бие даасан аймгуудын бүрдэл, нэгдлүүдээс тогтож байжээ. Сяньбийн аймгуудын бүрдэл (нэгдэл)-үүд нь хүн ам, цэрэг-улс төрийн хүч нөлөөгөөрөө харилцан адилгүй байсан бөгөөд зүүн хэсгийн буюу хожмын Таньшихуайн сяньби, табгач сяньби, баруун хэсгийн буюу Цифү болон Түфа сяньби, Муюн сяньби, Ляодунгийн сяньби (Ляоси сяньби) зэрэг томоохон аймгуудын нэгдэлээс гадна хүн хүч багатай жижиг аймгууд олон байжээ. Эдгээрээс цэрэг-улс төрийн хувьд хамгийн хүчирхэг төдийгүй өөрсдийн төр улсыг байгуулан, Төв Ази болон хойд хятадад ноёрхож байсан сяньби аймгуудын талаар Хятад сурвалж бичгүүдэд тэмдэглэн үлдсэн байна.

Хожуу Хан улс МЭ 220 онд мөхсөнөөс нүүдэлчид улам бүр урагшлан нутаглах болж, улмаар өөрсдийн улсуудыг байгуулан хятадад ноёрхох болжээ. Энэ үеийг Хятадын түүх бичлэгт “Умардын таван аймгийн арван зургаан улсын үе” гэх бөгөөд Хүннү угсааны Лю Юаньхай 304 онд Түрүү Жао (304-329) улсыг үндэслэн байгуулсанаар эхэлж, 439 онд Сяньби угсааны Тобачуудын байгуулсан Умар Вэй улс умард хятадыг нэгтгэснээр төгсдөг. Хятадын он дарааллын бичигт хүннү, цзеху, сяньби, ди, цян аймгийг “таван бүдүүлэг” (Wu hu) хэмээн нэрлэж байв.

Цифү аймгууд Баруун Цинь улс (385-431), Түфа аймгууд Өмнөд Лян улс (397-414), Муюн аймгууд Түрүү Янь улс (337-370), Хожуу Янь улс (384-409), Баруун Янь улс (386-394), Өмнөд Янь улс (398-410), Түгүхунь нарын Тогон улс (285-663), Тоба аймгууд Умард Вэй улс (386-534), Хятан аймгууд Ляо улс (916-1125)-ыг тус тус үндэслэн байгуулж¹, умард хятадад ноёрхож байснаас үзэхэд Дунхугийн угсааны монгол хэлт аймгууд тухайн үеийн Төв Азийн улс төрийн тавцанд чухал үүрэг гүйцэтгэж байсан нь тодорхой байна. Үүн дээр Юйвэнь аймаг Вэй улс унасны дараа байгуулсан хожуу Жоу улс, Ухуань, Күмоси, Дуань

¹Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху.М., 1984.с.4-5

зэрэг аймгуудын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, Жоужаний хаант улсын Төв Азийн түүхэнд эзлэх байр суурийг нэмж тооцвол тухайн үеийн Дунхугийн угсааны монгол хэлт аймгуудын эзлэх орон зай, хэмжээ далайц, ёсны түүхэнд Хятадын улсуудтай өргөн дэлгэр харилцаатай, цэрэг улс төрийн талаар нэлээд хүчирхэг нүүдэлчин аймаг, улсуудын талаар л бичихээс бус, харь угсааны бага жижиг аймгуудын талаар тэмдэглэдэггүй байсанд үндэслэвэл, Сяньбийн олон аймгуудаас хамгийн хүчирхэг бөгөөд тухайн үеийн улс төрийн тавцанд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж байсан аймгууд л тэмдэглэгдэн үлдсэн гэж үзэж болох юм.

Хятад сурвалжуудын мэдээ сэлтэд үндэслэн, Сяньби 鲜卑 (Xianbei) угсааны эдгээр аймгуудад:

1. Тоба (Табгачи) – 拓跋 (tuoba)
2. Цифү- 乞伏 (Qifu)
3. Түфа- 秃发 (Tufa)
4. Жоужань- 柔然 (rouan)
5. Түгүхунь- 吐谷浑 (Tuyuhun / tuguhun). 谷 нь "yu" гэж дуудагдахаас гадна "gu" гэж бас бас дуудагддаг учраас "түюйхунь" хэмээх нь ч буй.
6. Муюн- 慕容 (murong)
7. Күмоси- 库莫奚 (Kumoxi)
8. Хятан- 契丹 (Qidan) аймгуудыг багтаан үзэж, тэдний угсаа хамаатлын асуудлыг товчхон авч үзэв.

Тоба буюу Табгачи Сяньби. Сяньбийн олон аймгуудын хамгийн томоохон нь Тоба (拓跋 tuoba) юм. Энэхүү үгийн хятад эртний хэлбэр болох *t'akb'uat* гэдэг нь нутгийн хэлний *тайбат* гэсэнтэй тохирч, *тайбат* гэдэг нь түрэгчүүдийн хэрэглэж байсан, мөн табгач нарыг мөхсөн хойно ч хятад гэсэн утгаар хэрэглэж байсан Табгач *tabγas* буюу *tawγas* нэдэг нэрийн хувилбартай тохирч байгаа юм¹. Табгачийн Шийзьянь 338 онд Табгачийн Дай улсыг үндэслэн байгуулж, түүний ван болж, одоогийн ӨМӨЗО-ын Хорин гэр хошууны нутагт Шэнлэ хотыг нийслэл болгож, түүний дараа Табгач Гуй 386 онд ван болж, улсаа Вэй гэж нэрлэсэн нь түүхнээ Умард Вэй (386-534) гэж алдаршсан. Ийнхүү Табгач аймгууд Умард Вэй улс (386-534)-ыг үндэслэн байгуулж, хойд Хятадад ноёрхож байсан бөгөөд хожим нь Вэй улс дотоодын зөрчил, бослогын улмаас задарч Баруун Вэй (535-581) болон Зүүн Вэй (534-550) гэх хоёр улс болжээ.

"Вэй улсын судар"-ын "оршил цадиг"-т "Урьд шар хаан (黄帝 huangdi) хорин таван хөвгүүнтэй байжээ. Тэднээс дотоодын олон хятад ба гадаадын олон харь салбарлан гарчээ. Чан И хэмээгч бага хөвгүүнд умард нутгийг шагнан өгч, улсад нь Их Сяньби уул байдаг тул тийнхүү [Сяньби] нэрийджээ. Түүний хойчис нь эзэн тэргүүлэгч болж, Ю мужийн нийслэлээс хойших уудам говь, хээр талыг захиран, мал маллан нүүдэллэж, ан гөрөө хийн аж төрж байжээ. Зан суртал нь эгэл жирийн, ёс журам нь бүдүүлэг хялбар бөгөөд үсэг бичиг мэдэхгүй, модонд сийлэн тэмдэглэж, эртнээс эдүгээ хүртэл харилцан уламжлан ирсэн нь түүхчдийн тэмдэглэл мэт болжээ. Шар хаан шороон ёст ван тул умардын зуршлаар шороог то (托 tuo) хэмээж, хойчисыг нь ба (跋 ba) гэх тул ийнхүү [тоба] овогложээ. Түүний удам Ши Зюнь нь Яогийн үед түшмэл болж, ган гачигийн шулмыг Жо голоос хойш хөөсөн тул олон түүний гавьяанд түшиглэн, харин Шунь хаан түүнийг сайшаан тарианы өвөг болгожээ. Гурван төрийг

¹ Лигети Л. Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь. Хэл зохиол судлал. Tomus VII, Fasc 9, УБ., 1970. 227-228 дахь тал

Ю мужийн нийслэл гэж одоогийн Бээжин хот. Г.С

өнгөрөн Цинь, Хан улсын үе болоход хуңьюй, сяньюй, уулын жун, хүннү нарт багтаж олон үеийн турш дундад Жоуг үймүүлэн түйвээж байсан бөгөөд Ши Сюний удам Хятад оронтой харилцаагүй байсан болохоор судар тэмдэглэлд тэмдэглээгүй билээ. Жаран долоон үе болоод Чэн (成 cheng) хуанди (皇帝 huangdi) хүрч ирэв, түүний цээртэй нэр нь Мао (毛 mao). Тэр хүн хаан суугаад цэцэн мэргэн ухаантай, баатарлаг тул хол ойрынхондоо өргөмжлөгдөөд 36 улс, 99 том овгийг захирч, нэр сүр нь умар дахинд алдаршиж эс дагасан нь үгүй билээ"¹ гэж тэмдэглээд Мао хаанаас эхлэн Зефэнь хүртэл арван гурван хааны нэрийг дэс дараалан бичиж, заримтай нь холбоотой үйл явдлыг товч дурджээ. Тобагийн хаадыг хятадын домогт хаан Шар хааны удам болгон тайлбарласан нь нотолгоогүй зохиомол зүйл гэдгийг эрдэмтэд санал нэгтэй тэмдэглэсэн байдаг. "Оршил цадиг"-т үндэслэвэл, Мао хаан нь Тобагийн Шэнь Юань ди хаан (МЭ 220 онд хаан суусан)-ы арван дөрөв дэх дээд өвөг бөгөөд нэг үеийг 25-30 насаар тооцвол Мао хаан МЭӨ 200-130 оны үед амьдарч байжээ. Мао хаанаас дээш 67 үе гэдгийг мөшгөн хөөвөл (үеийг 25-30 насаар тооцвол) Ся улсын үе хүрч байна. Жаран долоон үеийн өвөг дээдэс гэдэг нь эргэлзээтэй боловч Сяньбийн Тоба овог эртний эх үүсэлтэй байсан нь бодит зүйл гэж үзэж болно. Тоба овог өөрсдийн өвөг дээдсийг Хятадын эртний домгийн хаадаас гаралтай болгон бичсэн нь хожимын Да Вэй улсын ноёрхогчдын улс төрийн шаардлагаас үүсэлтэй, эсвэл "Вэй шү"-ийн зарим хэсэг үрэгдэн хожим нөхвөрлөхөд Хятадын төрийн бодлогоор зориуд зохиосон зохиомол зүйл юм. Энэ талаар доктор Г.Сүхбаатар Мао хаанаас жинхэнэ Тобагийн домог эхэлж байгаа ба Мао хаан хүртэлх толгойн хэсэг нь зориуд хиймлээр Хятадын домогтой холбогдож байна гэж үзээд Мао хаан бол Хүннүгийн Маодунь шаньюй мөн гэжээ. Тэрээр дээрх саналыг дэвшүүлэхдээ дараах зүйлүүдийг үндэслэл болгосон байна. Үүнд: а) Алтай хэлтэн Тоба нар олон үет нэртэй байх ёстой. Тобагийн хаадыг Хятадын уламжлалаар ганц үет нэртэй болгосон. б) он цагийн хувьд Маодунь, Мао хоёр нь үндсэндээ нэгэн үед байна. в) Маодунь, Мао хоёрын гол үйл явдал яг тохирч байна. "Ши зи"-д бичсэнээр "Маодуны үед Хүннү нар урьд байгаагүйгээр хүчтэй болон, умар зүгийн бүх харь угсаатныг эзлэн, өмнө зүгт Хятадтай мөр зэрэгцэх улс байгуулсан. ... Маодунь умар зүгт хуңьюй, цюйшэ, динлин, гэгунь, синьли гэх орныг эзлэхэд Хүннүгийн бүх язгууртан хүмүүс, том түшмэд, түүнийг сэцэн гэж үзэн, түүнд захирагдсан" гэжээ. Иймд Мао хаан 36 улс байлдан дагуулсан гэдэг нь Маодуныхтай яг тохирч байна² гэсэндээ үндэслэн тоба нар Хүннүгийн ноёлогч хэсгийн шууд угсаа мөн нь ямар ч эргэлзээгүй бөгөөд улмаар тэдний угсаа гарвалын тухай хятад сурвалж бичгийн бусад мэдээгээр бүрэн нотлогдож байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Табгачи Сяньби нарын уугуул газар нутгийг тогтоох нь тэдний угсаа гарвалын судалгаанд чухал ач холбогдолтой. Хятад сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн Сяньби болон Их Сяньби уулыг тодруулах нь Табгачи Сяньби нарын уугуул нутгийг тогтооход чухал учир холбогдолтой юм.

"Хожуу хан улсын судар"-ын 90 дүгээр бүлэг "Сяньбийн шастир"-т "Сяньби хэмээгч нь дунхугийн салбар бөгөөд Сяньби ууланд очиж нутагласнаар тийнхүү нэрлэгджээ" хэмээн нэгэн Сяньби уулын тухай дурдсан бол үүнээс гадна "Вэй улсын судар"-ын нэгдүгээр боть "оршил цадиг"-т өөр нэг Сяньби уул буюу Их Сяньби уулын тухай тэмдэглэсэн байдаг.

Сяньбийн угсааны тоба нарын уугуул нутгийн талаар хятад сурвалж бичигт хэд хэдэн мэдээ байдаг. "Вэй шү"-ийн Улохоу улсын тухай 100 дугаар бүлэгт Шизугийн Жэньсюний 4 дүгээр он (443 он)-д Улохоугийн элч Их Вэй

¹ 魏書 (Wei shu), 卷1, 序紀. 中華書局出版, 第二版, 1984. 第1頁. Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971. 56-57; Лин Ган. Дурьдсан зохиол. 154-155 дахь тал

² Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980. 170 дахь тал

улсад ирээд манай улсаас баруун хойш Тобагийн дээдсийн байшин буй нь хойш урагшаа 90 алхам, баруун зүүн тийшээ 40 алхам, өндөр нь 70 чи гэж хэлсэн байна. Чингээд мөн тэр жил чжуншу шилан Ли Чанг илгээжээ. Ли Чан тахилга үйлдэн, байшингийн туурган дээр мөргөлийн үг сийлэн буцаж ирсэн гэж бичжээ. "Вэй шү"-ийн "Личжи" бүлэгт уг сүм Дай нийслэлээс хойш 4000 гаруй газар, Улохоугийн нутгаас баруун хойш гэж заажээ¹. Харамсалтай Улохоугийн нутгаас баруун хойш хэдий хэр хол байгааг тухайлан заасангүй. "Вэй шү"-д тэмдэглэгдсэн Сяньбийн дээдсийн сүм-чулуун өргөөний чулуунд сийлсэн магтаал гэдгийг эрдэмтэд үнэн бодитой биш, зохиомол зүйл гэж ихэвчлэн үздэг байжээ. Гэвч судлаачид чулуун өргөөг илрүүлэн, Их Хянганы давааны ар, Өвөр Монголын Хөлөн Буйр аймгийн Орчоны өөртөөн засах хошууны Ар гол балгасан дахь Гасянь агуй болохыг тогтоосон бөгөөд чулуунд сийлэгдсэн магтаал нь "Вэй шү"-ийн 108 дугаар бүлэг "ёслолын ойллого"-т тэмдэглэгдсэнтэй үндсэндээ адилаар ажээ². Ийнхүү 1980 онд Хятадын эрдэмтэд Сяньбийн чулуун өргөөний чулуунд сийлсэн магтаал бичээсийг илрүүлсэн нь Сяньбийн нутаглаж байсан газар нутгийг тогтоох, Сяньби уул ба Их Сяньби уулын асуудлыг шийдвэрлэхэд чухал түлхэц болж, Их Хянганы давааны өмнө хэсгийн Сяньби уулаас гадна Их Хянганы давааны ар хэсэгт бас нэгэн Их Сяньби уул байсан нь батлагдсан байна.

Сяньби өөрсдийгөө Тоба хэмээн нэрлэсэн төдийгүй уг нэр Их Сяньби ууланд суурьшин малжиж байсан Сяньбичуудын эртнээс нэршиж ирсэн нэрийдэл болох нь тодорхой байна.

П.Пеллио "Умард Хятадыг дундад эртний үед түрэгчүүд табгач, арабчууд тамгаж, Византын гөрөгчүүд таугас гэж нэрлэж байсан уг үг нь тоба мөн юм хэмээн "Тунбао" сэтгүүлд 1912 онд бичсэнийг үндэслэн эрдэмтэдийн олонхи нь табгач, тамгаж зэргийг тоба гэсэн үг хэмээн бичсээр иржээ.

"Да Вэй улсын Тоба Гуй (Сяовэньди) хаан бүр 495 онд тоба овгийн нэрийг Юань (язгуур) овог хэмээн өөрчилсөн бөгөөд ер нь тоба гэдэг нэр улсыг төлөөлөн түгсэн нэр бус байсан юм. "Суншугийн" 57 дугаар бүлэг Чжан-чангийн намтарт "Чжан Чан боолуудын (Вэй улсын) элчээс овгийг нь асуухад сяньби, ихэнхдээ морин дэл дээгүүр амьдардаг" гэсэн бол, Тоба Дао хаан өөрийгөө сяньби гэж нэрлэж байсан байна³. "Тоба бол сяньбийн эртний нэг овог, өөрөөр хэлбэл, тоба бол Да Вэй улсын ноёлогч 10 овог дотроос зөвхөн хааны угсааныхны овог юм. Ингэхлээр тоба нар бол тоба бус олон сяньби аймгийн хүмүүс байжээ"⁴ гэж доктор Г.Сүхбаатар үзээд руни бичгийн дурсгалуудад дурдагддаг "табгачи" гэдэг үг нь "Да Вэй"-ийн сунжирсан дуудлага, харин тоба гэдэг үгийг монгол хэлний "дов" гэсэн үг байж болох юм гэсэн байна.

Хятад сурвалжид тоба, тефу, түфа гэх мэт олон янзаар тэмдэглэснийг нэг нэр хэмээн судлаачид үзсээр ирсэн. Тобагийн уг гарлын талаар "Вэй шү"-ийн 95 дугаар бүлэгт "Туфугийн Люху бол өмнөд шаньюйн [хүннүгийн] удам ... умар зүгийн хүмүүс ху [хүннү] эцэгтэй, Сяньби эхтэйг туфу гэдэг тул ийнхүү нэрлэжээ", "Нань ци шү"-ийн 57 дугаар бүлэгт "Вэйлу (Вэй улсын боолууд буюу тоба) бол хүннү аймаг, тоба овогтой ... (тобагийн) Илу нь Дайзюнь мужид ирж нутагласан, мөн Сяньби гэдэг юм"⁵ гэсэн сурвалжийн мэдээг "Зинь шү"-ийн 126 дугаар бүлэгт "Түфа (秃发) Угү (乌孤 wugu) бол Хэсигийн Сяньби (河西鲜卑 hexi xianbei) хүн юм. Дээдэс нь Хожуу Вэй (后魏)-тэй нэг гаралтай (同出). Наймдугаар үеийн өвөг Пигү (匹孤 pigu) нь аймгаан дагуулж, бэхлэлт хэрэмний [цагаан

¹ Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971. 26 дахь тал

² Лин Ган. Дунхугийн түүх. ӨМАХХ. 1997. 154 дэх тал

³ Сүхбаатар Г. Хүннү, Сяньбийн хоорондын угсаа гарлын холбогдол // ТС. Т.VIII, F. 4, УБ., 1969. 55 дахь тал

⁴ Сүхбаатар Г. Хүннү, Сяньбийн хоорондын угсаа гарлын холбогдол // ТС. Т.VIII, F. 4, УБ., 1969. 55 дахь тал.

⁵ Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971. 30 дахь тал

хэрэм] араас Хэсид нүүдэллэн ирсэн ажгуу. Пигүг үхэхээр хүү Шоутянь нь ор суужээ. Анхан Шоутянь гэдсэнд байхад нь эх Хуе овогт нь нойрондоо хөнжилд төрүүлжээ. Сяньбигаар хөнжлийг “түфа” (秃发 tufa) хэмээх тул ийнхүү овогложээ”¹ хэмээн өгүүлсэнтэй харьцуулан доктор Г.Сүхбаатар “Тобагийн гарлын тухай сурвалж бичгийн мэдээ, эрдэмтдийн судалгааг нягталж үзэхэд хүннү, сяньби хоёр бол хоёр талын байнгын худ ургийн холбоотой байсан, өөрөөр хэлбэл, овгийн байгууллын үеийн давхар байгууламжаар холбоотой байсны ул мөр, улбаа тод үзэгдэж байна гэж үзэж бүрэн болно. Нэгэнт давхар байгууламжаар холбоотой байсан болохоор хүннү, сяньби хоёрын гол үндсэн хэсэг нь угсаа гарлын хувьд нэгэн угсаатан мөн гэж дүгнэж болно”² хэмээжээ. Ма Чаншоу туфагийн Пигугийн эхнэрийн хуе овгийг Хүннүгийн хуянь овог мөн гээд сяньби, хүннү хоёрын нэн эртнээс ураг барилдаж байснаас “ху (хүннү) эцэгтэй, сяньби эхтэй”-г тефу буюу тефа хүннү, “сяньби эцэгтэй, ху эхтэй”-г тоба буюу туфа сяньби гэдэг. Иймд тобагийн Вэй улсын “Тоба” хэмээх нэр нь хожим үүссэн бөгөөд хүннү сяньби холилдсоны үр дүн мөн³ гэж үзсэн байна. Ма Чаншоугийн нотолсноор Хүннүгийн хуянь, Сяньбийн тоба овог хоорондоо байнгын худ ургийн холбоотой байсан бөгөөд уг саналыг Г.Сүхбаатар дэмжжээ.

Сурвалжийн дээрх мэдээ баримтуудаас үзэхэд, Тоба нь эртний сурвалжит овог төдийгүй Хүннү, Сяньбитай угсаа гарвалын нягт холбоотой болох нь харагдаж байгаа боловч “Зинь шү” болон “Вэй шү”-ийн мэдээнээс үзэхэд Тоба, Түфа хоёр нь нэг нэр бус, Сяньбийн хоёр аймгийн нэр болох нь тодорхой байна. “Зинь шү”-ийн 126 дугаар бүлэг “Түфа Угү-ийн намтар” болон “Вэй шү”-ын 99 дүгээр бүлэг “Түфа Угү-ийн намтар”-т өгүүлснээр Түфа сяньби нь Өмнөд Лян улсыг байгуулан, хойд хятадад ноёрхож байсан сяньбийн нэгэн аймаг ажээ.

“Вэй шү”-ийн 113-р бүлэгт Тобагийн 118 овгийн талаар тэмдэглэснийг эрдэмтэд судалсаар ирсэний дотор К.Ширатори, В.Эберхард, Л.Базел, Яо Вэй-юань, Г.Сүхбаатар зэрэг эрдэмтэд хэл болон түүх, угсаа гарвалын талаас нь судалж, хэд хэдэн өгүүлэл, нэгэн сэдэвт зохиол тууриулав. Доктор Г.Сүхбаатар “Тобагийн овгийн нэр цөм хятад дүрс бичгийн эртний ойролцоо дуудлагаар байгаа болохоор жинхэнэ уг эх хэлээрээ ямар байсныг онож олох нь одоогийн шатанд тун бэрхтэй” болохыг дурдаад “эдгээр овгийн зарим нэр нь балар эртний тотем овгоос уламжилсан нэр байж болох юм. Иймд тийм овгийн нэрийн утгыг тэр үед ч гэсэн мэдэж, ойлгож байсан гэхэд бэрхтэй”, “ихэнх овог нь мэдээжийн хэрэг эртний тотемын овгоос салбарласан бөгөөд гол төлөв ямар нэгэн хүний нэрээр нэрлэсэн байв. Иймд Тобагийн овог бүхний нэрийг дуудлагын аль нэг ойролцоо байдлыг баримтлан заавал алтай хэлний нэг хэлэнд хүчээр тулган нийлүүлээд, түүндээ тулгуурлан сяньби тобагийн удам угсааны талаар дүгнэлт хийвэл сүрхий ташаарал болох нь эргэлзээгүй”⁴ хэмээсэн нь арга зүйн чухал ач холбогдолтой бөгөөд зарим эрдэмтдийн судалгаанд дээрх алдаа байгааг шүүмжилсэн байдаг. Тобагийн “Тоба” овгийн нэрийг 494 онд өөрчилж “юань” хэмээн нэрийдсэн бөгөөд 495 оноос бусад овгуудын нэрийг мөн өөрчлөн, олон үет нэрийг ганц үет нэр болгон, заримыг хятадаар орчуулан хэрэглэх болсон байна. Тухайлбал, Тобагийн язгууртны 10 овгийн нэрийг:

1. Тоба овог-Юань
2. Хэгу овог-Ху

¹ 晋书jinshu. 卷126. 秃发乌孤. 中华书局. 1999. 第2111页.

² Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971. 31 дэх тал

³ 马长寿. 乌桓与鲜卑. 上海. 1962. 第30-31页

⁴ Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971. 39 дэх тал

3. Пу овог-Жоу
4. Баба овог-Чан сунь
5. Даси овог-Си
6. Илоу овог-И
7. Цюдунь овог-Цю
8. Хоу овог-Хай
9. Ижань овог-шусинь
10. Чэгунь овог-Чэ гэж тус тус өөрчлөн нэрлэсэн ажээ.

Сяньбийн хэлний талаарх хятад сурвалжийн мэдээ сэлт ховор боловч, Сяньбийн нэгэн аялгуу болох Табгач хэлний талаар дүгнэлт хийж болохуйц зарим мэдээ баримт тэмдэглэгдэн үлджээ.

Тоба нар өөрийнхөө хэлээр олон ном зохиол зохиож байсан тухай хятад сурвалжийн мэдээ баримт байдаг. Тухайлбал, "Вэйгийнхэн (тоба нар) Ляон хотод нүүж очоод хятад хэлээр нэвтрэхгүй тул Сяовэньди хааны зарилгаар Хоуфухоугийн Кэси-лин "ачлалт номыг" харь (тоба) хэлээр орчуулан, улсын иргэдэд зааж, төрийн (тоба) хэлний "ачлалт ном" хэмээн нэрлэх болжээ"¹ хэмээн тэмдэглэн үлдээжээ.

"Сүй шү"-ийн 32 дугаар бүлгийн номын бүртгэлийн хэсэгт Сяньби хэлээр бичсэн дор дурдсан номын нэрийн жагсаалт хадгалагдан үлдсэн байна.

1. "国语", 十五卷 (guoyu, shiwujuan)-Төрийн хэл, 15 бүлэг
2. "国语", 十卷 (guoyu, shijuan)-төрийн хэл, 10 бүлэг
3. "鲜卑语", 五卷 (xianbeiyu, wujuan)-Сяньби хэл, 5 бүлэг
4. "国语物名", 四卷 (guoyuwuming, shijuan)- төрийн хэлээрх юмны нэр, 4 бүлэг. Хоуфухоу цолтой Кэси мин зохиосон.
5. "国语真歌", 十卷 (guoyuzhenge, shijuan)- төрийн хэлээрх жинхэнэ дуунууд, 10 бүлэг
6. "国语杂名", 三卷 (guoyuzaming, sanjuan)- төрийн хэлээрх янз бүрийн номын нэр, 3 бүлэг. Хоуфухоу цолтой Кэси мин зохиосон.
7. "国语十八传", 一卷 (guoyushibafu, yijuan)- төрийн хэлээрх 18 цадиг, 1 бүлэг
8. "国语御歌", 十一卷 (guoyuyuge, shiyijuan)- төрийн хэлээрх ордны дуу, 11 бүлэг
9. "鲜卑语", 十卷 (xianbeiyu, shijuan)-Сяньби хэл, 10 бүлэг
10. "国语号令", 四卷 (guoyuhaoling, sijuan) -төрийн хэлээрх зарлиг тушаалууд, 4 бүлэг
11. "国语杂文", 十五卷 (guoyuzawen, shiwujuan) -төрийн хэлээрх янз бүрийн зохиолууд, 15 бүлэг
12. "鲜卑号令", 一卷 (xianbeihaoling, yijuan)²-Сяньбийн зарлиг тушаалууд, 1 бүлэг. Жоугийн эзэн хаан У-ди зохиосон. Ном зохиолд дурдсан эдгээр бүтээлүүдээс гадна

¹ Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971. 118 дахь тал

² 隋书.sui shu. 卷 32. 第945页.

13. 国语孝经,一卷 (guoyuxiaojing, yijuan)-ачлалт ном төрийн хэлээр, 1 бүлэг зохиолыг зааж болно. К.Ширатори, Г.Шрейбер нар дээрх номын нэрийг үндэслэн “төрөлх хэл буюу төрийн хэл”, “Сяньби хэл” хоёр нь нэг зүйл байсан бололтой гэж тогтоожээ. Эл хоёр нэр томъёоны ганцхан ялгаа гэвэл түрүүчийнх нь Вэй улсын үеийн сяньби хэлийг, хоёр дахь нь Вэй-гийн дараах улсуудын үеийн буюу тухайлбал, Хойд Жоу улсын мөн хэлийг заан өгүүлсэн хэрэг юм.¹ Л.Лигети “4 ба 6 дугаар номуудыг Вэй улсын үед амьдарч байсан зохиогч “төрөлх хэл” (төрийн хэл)-ээр бичсэн гэж байсан бол сяньби хэлээр бичсэн 12 дугаар ном нь Жоугийн эзэн хаан У-ди (561-578)-ийн бичсэн зүйл гэдэг нь баримтаар нотлогдож байна. Дурдсан жагсаалтын тэн хагас болох зургаан бүтээл нь табгач буюу сяньби хэлний тухай ном байсан гэдэг нь лавтай. 4, 6 дугаар ном нь улсын хэлний тухай мэдээ сэлтийг олж мэдэхийг хүссэн хятад хүмүүст зориулж зохиосон хятад табгач толь бичиг байжээ. 10, 11, 12 дугаар номд сяньби хэлээр бичсэн зарлигийн эх, зохих хятад орчуулгын хамт байсан байж болох юм”² гэж үзжээ. Хэдийгээр Сяньби буюу Табгач хэлээр бичигдсэн ном зохиолуудаас нэг ньч хадгалагдан үлдээгүй боловч, эдгээр номын нэрийн жагсаалт нь Тоба нар Сяньби хэлээр ярьдаг байсныг, Сяньби хэл төрийн албан ёсны хэл (国语 guoyu) байсныг баталж байна.

Түфа 禿發(tufa) Сяньби. Түфа Угү-ийн наймдугаар үеийн өвөг Пигү-ийн үед аймаг олноон дагуулж, говийн араас Хэси (Хатан голын баруунтай)-д ирж сууснаас бас Хэси Сяньби гэж нэрлэдэг. “Зин улсын судар”-ын 126 дугаар бүлэг “Түфа Угү-ийн намтар”-т “Түфа (禿發) Угү (烏孤 wugu) бол Хэсигийн Сяньби (河西鮮卑 hexi xianbei) хүн юм. Дээдэс нь Хожуу Вэй (后魏)-тэй нэг гаралтай (同出). Наймдугаар үеийн өвөг Пигү (匹孤 pigu) нь аймгаан дагуулж, бэхлэлт хэрэмний [цагаан хэрэм] араас Хэсид нүүдэллэн ирсэн ажгуу. Пигүг үхэхээр хүү Шоутянь нь ор суужээ. Анхан Шоутянь гэдсэнд байхад нь эх Хуе овогт нь нойрондоо хөнжилд төрүүлжээ. Сяньбигаар хөнжлийг “түфа” (禿發 tufa) хэмээх тул ийнхүү овогложээ”³ гэсэн бол “Вэй улсын судар”-ын 99 дүгээр бүлэг “Түфа Угү-ийн намтар”-т “Түфа Сяньбийн Угү-ийн 8 дугаар үеийн Пигү умард зүгээс Шармөрөний баруун талд шилжин суусан. Түүний нутаг зүүн зүг Майтянь ба Цяньтунь, баруун зүг Шило, өмнө зүг Зяохэ, умар зүг их говь хүрнэ”⁴ хэмээсэн байна. “Вэй шү”-ийн 41 дүгээр бүлэг “Юанхэ-ийн намтар”-т өгүүлсэнээр Юанхэгийн уул нэр нь Түфа Поциан, Хэси ван Түфа Нутанийн хөвгүүн ажээ. Нутань нь 441 онд Цифүгийн Шифэнд мөхөөгдсөний дараа, Юаньхэду (одоогийн Хөхнуурын Лэду сянь)-аас Умард Вэй улсад дагаар орсонд, Шизу Тай Уди (Табгачи Дао) хаан Хэ-д өгүүлсэн нь: “Түшмэл та надтай язгуур нэг бөлгөө. Учир шалтгааны улмаас овог салбарласан билээ. Эдүгээ та Юань овгийг авч болно”⁵ хэмээжээ. Ийнхүү Умард Вэй улсын хамгийн дээд язгууртан Түфатай нэг язгууртай болохоо хүлээн зөвшөөрч байгаа нь тэд нэг угсаа гаралтай болохын баталгаа гэж үзэж болох юм. “Шинэ Тан улсын судар”-ын “Зайсянгийн үе залгамжлалын хүснэгт”-д өгүүлснийг үндэслэвэл, Юань овог нь Умард Вэй улсын Шэн Уди хаан Зефэний хөвгүүн Сихү-ээс үүссэн ажээ. Тан улсын Лин Бао-ын туурвисан “Юань хэсин юань” бичгийн 10 дугаар бүлэгт Хэсийн Сяньби

¹ Лигети Л. Табгач хэл сяньбийн нэгэн аялгуу болох нь. 229 дэх тэл

² Лигети Л. Дурдсан зохиол. 229-232 дахь тал.

³ 晋书jinshu. 卷126. 禿發烏孤. 中华书局. 1999. 第2111页.

⁴ 魏書 (Wei shu), 卷99, 鮮卑 禿發烏孤 (Xianbei tufa wugu). 中華書局出版, 第二版, 1984. 第2200頁

⁵ 魏書 (Wei shu), 卷 41, 源賀(yuan he). 中華書局出版, 第二版, 1984. 第919頁

Түфа овогтон болон Умард Вэй улс нь угсаа нэгтэй юм. Сихү бол Зефэний ахмад хөвгүүн. Шэн Юань ди хаан Ли Вэй (Зефэний дэд хөвгүүн)-ийн үед аймаг олноон дагуулж Хэсид нүүн ирсэн¹ хэмээн тэмдэглэжээ. Ли Вэй хаан МЭ 220-277 онд хаан сууж байсан болохоор Лигү МЭ II зууны дунд үе орчим Хэсид шилжин суусан хэмээн үзэж болохоор байна.

Түфа Сыфузянь нас барж, хүү Угү залгамжилжээ. Угү нь "эрэлхэг баатар, алсын бодлоготой" нэгэн байсан бөгөөд энэ үед Люй Гуан ид хүчирхэг байсан тул түүнээс өргөмжилсөн цэргийн их манлай жанжин, Хэсигийн сяньбийн их захирагч (дүдү) өргөмжилсөнийг хүлээн авчээ. Угү өөрийн хүч чадлыг бэхжүүлэхийн тулд Зүүн Зин улсын Тай-Юаны хорьдугаар он (395 он)-д баруун талд суурьшиж байсан Ифу, Жоцюй зэрэг Сяньби аймгуудыг довтлон өөртөө нэгтгэж авч, Лянчуаньбао (одоогийн Хөхнуурын Лэду сяний зүүн хойно)-гаар төвлөрөх болов. Үүний дараа Гуан У (одоогийн Ганьсугийн Юнчан сяний зүүн өмнө) орчим сууж байсан Юнь сяньби аймгийг нэгтгэснээр сүр хүч нь аажмаар өссөөр байлаа.²

Зүүн Зинь улсын Ань Дя хааны Лунань (隆安long an)-ы тэргүүн он (397 он)-д Угү өөрийгөө их захирагч (大都督 dadudu), их жанжин (大將軍 dajiangjun), их шаньюй (大单于dachanyu), си пин ван (西平王 xipingwang) өргөмжилж, оны цолоо Тай Чу (太初 taichu) хэмээж, Өмнөд Лян улсыг үндэслэн байгуулжээ.³ Дараагаар нь Люй Гуанын Зиньчэн зюнийг эзэлж, Люй Гуанын цэргийг Зетин (одоогийн Ганьсу мужийн Ланьжоу хотын Юндэн сяний ойролцоо)-д ялсан байна. Ингэснээр Хэнань (одоогийн Ганьсу мужийн Ланьжоу хотын Хатан голын өмнө) дахь Сяньбийн Думо зэрэг арван хоёр аймаг бүгд дагаар оржээ.⁴ Тухайн үед Хэсигийн газар нутагт Хойд Лян улсын Люйгуан нь Гүцан (одоогийн Ганьсугийн Увэй хот)-д байснаас гадна, Баруун Цинь улсын Цифү Ганьгүй нь Юаньчуань (одоогийн Ганьсугийн Южүн сяний зүүн хойно), Умард Лянгийн Дуань Е нь Жан Е-д сууж, бүгд хүчирхэг байсан тул Угү олон түшмэлээсээ асуусан нь "Лүншанаас баруун тийшх нутаг том биш, чухамдаан хэдэн зюний нутаг билээ. Самууран бутарч, тэмцэлдсээр арав гаруй эзэмшилд хуваагджээ. Люй овогт, Цифү овогт, Дуань овогт нь хамгийн хүчирхэг билээ. Эдүгээ дээрх газрыг эзлээ хэмээвээс гурван хүчний алиныг нь урьдаар довтлох вэ?" хэмээвээс Ян Тун (楊統 yang tong) өгүүлсэн нь: Ганьгүй чухамдаа бидэнтэй гарал нэгтэй болох тул, эрт оройгүй дагуулж болно. Дуань Е (段业 duan ye) бичигтэн эр, манайд халдах чадал үгүй, бидэнтэй анд бололцсон учир дайлан цохих журам үгүй буюу. Люй Хуан (呂光 lu guang) өтөлж, залгамжлах хүү нь сул дорой, Жуань, Хун (Люй Жуань, Люй Хун) хэдийгээр эрдэм чадалтай боловч, хоорондоо зөрчил тэмцэлтэй тул, хэрвээ Хао Мэн, Лянь Чуанийхан завшааныг ашиглан довтолбоос тэд лавтайяа амиа бодон зугтан одох болохоор хоёр жил хүрэхгүй цэрэг, ард нь ядран туйлдахаар Гүцаныг эзэлж болно. Гүцаныг эзлэн авсан байхад хоёр хулгай (Ганьгүй болон Дуань Е) өөрсдөө дагаар орох болно⁵ гэсэнд Угү дэмжин сайшааж, хөрш орнуудтай дайтах төлөвлөгөөгөө боловсруулжээ. Гэвч Угү төлөвлөгөөгөө хэрэгжүүлж амжилгүй, удалгүй нас барсан байна.

Угүг түүний дүү Лилүгү (利鹿孤 lilugu) залгамжилж, Сипин (西平 xiping) хотоор нийслэлэх болж, оны цолоо Зяньхэ хэмээн нэрлэжээ.

¹ Лин Ган. Дурдсан зохиол.

² Лин Ган. Дурдсан зохиол. 216 дахь тал

³ 晋书jinshu. 卷126. 秃发乌孤. 中华书局. 1999. 第2112页.

⁴ Лин Ган. Дурдсан зохиол. 217 дахь тал

⁵ 晋书jinshu. 卷126. 秃发乌孤. 中华书局. 1999. 第2112页.

Цян үндэстний Ю овогтоны байгуулсан Умард Цинь улс (нийслэл нь Чан-Ань) хүчирхэгжсэнээс Баруун Цинь улсын Цифү Ганьгүй хойд Цинь улсад дагаар орж, Лунсигийн Ли Гао нь Ганьсугийн Дунхуаньд баруун Лян улсыг байгуулж, Умард Цинь улсыг довтолон цохисноор Хэси нутагт хүчирхэгжин байсан Умард Цинь улсын түрэлтийг нэг үе хязгаарлав.

Зяньхэгийн гуравдугаар он (402 он)-д Лилүгү нас барж, түүний дүү Нутань (拊檀 nutan) залгамжилан, өөрийгөө Лян ван (凉王 liang wang) хэмээн өргөмжилж, оны цолоо Хунчан (弘昌 hongchang) хэмээн Лэду (乐都 lèdu)-д нийслэлэх болжээ.

400 онд Умард Цинь улсад дагаар орсон Баруун Цинь улс, дотоодын хямрал тэмцлийн улмаас Умард Цинь улсын Хэси дэх улс төрийн нөлөө буурсныг ашиглан, 409 онд төр улсаа дахин сэргээснээр Өмнөд Лян улстай зөрчилдөх болсон байна. Үүнээс гадна Өмнөд Лян улсын Нутань, Умард Лян улстай тэмцэлдэн байлдсан ч удаа дараа ялагдсанаар сүр хүч нь доройтон, дотоодын хямрал тэмцэл гарах болжээ. Ийм үед Цифү нарын Баруун Цинь улс аажмаар Ганьсугийн баруун нутгийг эзэмших болж, Өмнөд Лян улсыг байнга довтолж, нэлээд хэмжээний газар нутгийг нь эзлэн авчээ. Зяпиний 7 дугаар он буюу Зин улсын Исигийн 10 дугаар он (414 он)-д Баруун Цинь улс дахин довтолж, Нутань буун өгсөнөөр Өмнөд Лян улс мөхжээ.

Түфа сяньби аймгуудын үндэслэн байгуулсан Өмнөд Лян улс нь Зүүн Зин улсын Лунань (隆安 longan)-ийн тэргүүн он (397 он)-оос Иси (义熙 yixi)-ийн 10 дугаар он (414 он) хүртэл арван найман жил тогтносон бөгөөд Өмнөд Лян улсын "хүчирхэг үеийн газар нутаг нь голдуу У Вэй, Ушин, Фэньхэ, Сизюнь, Чансүн, Лэдү, Сипин, Гуан У, Зяохэ, Хуанхэ, Саньхэ, Синзин зэрэг зюн байж, ихэвчлэн одоогийн Ганьсу мужийн Ланьжоу хотоос баруунш, Хөхнуураас зүүнш, Түнжэнь саяниас хойш, Тэнгэр элснээс өмнөх газрыг багтааж байжээ".¹

Түфа сяньби аймгуудын байгуулсан Өмнөд Лян улс (397-414) нь удаан оршин тогтнож чадалгүй Цифү сяньби нарын байгуулсан Баруун Цинь улсад цохигдон мөхсөн ч Түфа аймгууд умард хятадын улстөр, угсаа соёлын хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ялангуяа, Ганьсу, Хөхнуурын цян угсаатан бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж болохоор байна.

Цифү 乞伏 (qifu) Сяньби. Цифү нар нь сяньби аймаг бөгөөд Баруун Цинь улс (385-431)-ыг байгуулж байжээ.

"Зин улсын судар"-ын 125 дугаар бүлэг "Цифү Гожэний намтар"-т "Цифү Гожэнь (乞伏国仁 qifu guoren) хэмээгч нь Лунсигийн Сяньби (陇西鲜卑 longxi xianbei) хүн юм. Урьд Жуфусы (如弗斯 rufusi), Чүлян (出连 chulian) болон Чилү (叱卢 chilu) хэмээх гурван аймаг байжээ. Говийн араас өмнөш нүүж Да Иньшань (大阴山 dayinshan) ууланд ирсэн"², "Вэй улсын судар"-ын 99 дүгээр бүлэг "Цифү Сяньби Гожэний намтар"-т "Цифү Гожэнь хэмээгч нь Лунси (隴西 long xi)-ийн Сяньби хүн юм"³ хэмээн тэмдэглэжээ. Цифү Сяньбийг бас Лунси (隴西) Сяньби гэдэг. Лунси Сяньби гэдэг нь Луншаны (одоогийн Люпаньшаний өмнөд хэсэг) баруун талд суурьшиж байсан Сяньби гэсэн утгыг илтгэдэг бөгөөд энэ уул нь одоогийн Шэньсийн Лунсяний баруун хойноос Шэньси, Ганьсугийн хязгаараар сунаж тогтсон уул мөн ажээ.⁴ Цифү Сяньби нар хэдийд өмнө зүг нүүдэллэснийг

¹ Лин Ган. Дунхугийн түүх. 227 дахь тал

² 晋书(jin shu). 卷125, 乞伏国仁. 中华书局. 1999. 第2093页.

³ 魏書 (Wei shu), 卷 99, 鮮卑乞伏國仁. 第2198頁

⁴ Лин Ган. Дурдсан зохиол. 233 дахь тал

сурвалжид тэмдэглэсэн нь үгүй боловч Гожэнийн тавдугаар үеийн дээд өвөг Юлинь нь Зин улсын Тай-ши (265-274)-ийн эхэн үед Сяньбийн нэгэн аймгийн тэргүүн Лузетэй Гаопинчуаньд байлдсанд үндэслэн, нэг үеийг 25 жилээр бодвол он цагийг барагцаалан тогтоож болно.

“Зин улсын судар”-ын 125 дугаар бүлэг “Цифү Гожэний намтар”-т “Түүний хойчис Юлинь (佑郢) хэмээгч Гожэний тавдугаар үеийн дээд өвөг бөгөөд Тай-ши (泰始 taishi) [265-274]-ийн эхэн үед таван мянган өрх дагуулан Ся-ын хилд нүүн ирж, аймаг олон нь хүчирхэгжээ. Сяньби Лузе (鲜卑鹿结 xianbei lujie)-ийн долоон түмэн өрх нь Гаопинчуань (高平川 gaopingchuan)-д суух аж. Юлиньтай харилцан дайтахад, Лузе ялагдан өмнө зүг Люзянь (略阳 lueyang) тийш зугтан одоход, Юлинь түүний аймаг олныг өөртөө нэгтгэн авч Гаопинчуаньд суурьшжээ. Юлинь нас нөхцөхөд түүний хөвгүүн Зецуань (结权 jiequan) залгамжилж, Цяньтуньд (牵屯 qiantun) шилжин суув. Зецуаныг хүү Лина (利那 lina) залгамжилж, Сяньбийн Тулай (鲜卑吐赖 xianbei tulai)-г Ушушань (乌树山 wushushan)-д дайлан, Кэцюань, Юйчийг Дафэйчуаньд цохиж, гурван түмэн илүү өрхийг хураан захирчээ. Линаг түүний дүү Цини (祁尼 qini) залгамжилсан бөгөөд түүнийг Линагийн хөвгүүн Шүянь (述延 shuyan) залгамжлан, Сяньбийн Мохоу (鲜卑莫侯 xianbei mohou)-г Юаньчуань (苑川 yuanchuan)-д дайлан төрийн хэлээр ихэд ялж, түүний хорин мянга гаруй өрхийг өөртөө нэгтгэн авч Юаньчуаньд суужээ”¹ хэмээн Цифү Сяньби нарын өмнө зүг шилжин суурьшсан үйл явцыг нэлээд дэлгэрэнгүй тэмдэглэн үлдээжээ.

“Зин улсын судар”-ын 125 дугаар бүлгийн “Цифү Гожэний намтар”-т тэмдэглэснээр Зүүн Зин улсын Тай Юань (太元 taiyuan)-ы тэргүүн он (376 он)-д Сыфань (司繁 sifan) үхэж, хүү Гожэнь суурийг нь залгамжилжээ. Гожэний үед Цифү аймгууд үлэмж хүчирхэгжиж байхад, хөрш зэргэлдээ Хятадын улсууд хоорондын зерчил мөргөлдөөнөөсөө болж хүч чадал нь улам бүр суларч байсан.

Тай-Юань (太元 taiyuan)-ы 10 дугаар он (385 он)-д Гожэнь өөрийгөө их захирагч (大都督 dadudu), их жанжин (大将军 dajiangjun), их шаньюй (大单于dachanyu)-гаар өргөмжилж, оны цолоо Зянь И (建义 jianyi) хэмээн нэрлэж, төрийн түшмэдүүдийн зэрэг дэвийг шинэчлэн тогтоож, харьяат газар нутгаа Учэн (武城 wucheng), Уян (武阳 wuyang), Аньгу (安固 angu), Уши (武始 wushi), Ханьян (汉阳 hanyang), Тяньшуй (天水 tianshui), Люзянь (略阳 lueyang), Цянчуань (强川 qiangchuan), Ганьсун (甘松 gansong), Куанпэн (匡朋 kuangpeng), Байма (白马 baima), Юаньчуань (苑川 yuanchuan) гэсэн арван хоёр тойрог (郡jun)-т хуваан, Юнши (勇士 yongshi) хотыг нийслэлээ болгожээ.² Ийнхүү Цифү Гожэний хийсэн төр-засаг захиргааны шинэтгэл нь төр улсын хөгжлийг шинэ шатанд гаргаж, Баруун Цинь улсыг үндэслэн байгуулсан байна.

Энэ талаар Хятадын эрдэмтэн Лин Ган “Энэ бол Цифү овогтны төр байгуулсны эхлэлт мөн. Сүүлд нь Гожэний дүү Ганьгүй өөрийгөө Цинь ван хэмээн өргөмжилсөн тул түүхэнд Баруун Цинь улс гэдэг” хэмээжээ. Цифү аймгуудын манлайлал дор сяньби, хүннү угсааны зарим аймгуудаас гадна Цян угсааны аймгууд ч нэгдсэн байна. Баруун Циний өмнө талд цян угсааны аймгууд байсан бөгөөд тэдгээрээс Цянжоугийн орчмын цянчууд хамгийн хүчирхэг нь байв. Цяньчуань бол одоогийн Ганьсу мужийн өмнө хэсгийн Сидин шаны зүүн

¹ 晋书(jin shu).卷125, 乞伏国仁. 中华书局.1999. 第2093页.

² 晋书(jin shu).卷125, 乞伏国仁. 中华书局.1999. 第2094页.

хойно буй. Гожэнь энд Цянчуань тойргийг байгуулсан нь даруй энэ орчмын Цян нар баруун Цинь улсыг дагаж байсныг харуулж байна. Цянчуаниас баруун ба өмнө зүгт харин Тогон аймгууд төр улсаа байгуулсан байна.¹

Зүүн Зинь улсын Тай Юаны 14 дүгээр он буюу 388 онд Цифү Гожэнь нас барахад түүний хүү нас бага балчир байсан учраас Гожэний дүү Ганьгүй (乾归 gangui) "эрэлхэг баатарлаг, дайчин гарамгай, чин зоригт, уужуу тайвуу, тэвчээртэй" тул түүнийг их захирагч (大都督 dadudu), их жанжин (大将军 dajiangjun), их шаньюй (大单于 dachanyu), мөрний өмнөх ван (河南王 hennanwang)-гаар өргөмжилж, оны цолоо Тай Чү (太初 taichu) хэмээн нэрлэж, олон түшмэд, жанжидыг томилон, нийслэлээ Зиньчен (金城 jin cheng)-д (одоогийн Ганьсу мужийн Ланьжоу хотын баруунтаа) шилжүүлжээ.²

Зин улсын Лунань-ийн дөрөвдүгээр он буюу 400 оны 5 сард Хойд Цинь улсын хаан Яо Син (姚兴 yaoxing) тавин мянган цэргээр Наньанься (南安峡 nananxia-одоогийн Ганьсу мужийн Жанзячуаны баруун)-аас баруун Цинь улсыг довтлоход, Цифү Ганьгүй бүх цэргээ хөдөлгөн байлдсан ч шийдвэрлэх тулалдаанд ялагдан, Ганьгүй өмнөд Лян улс руу зугтаан очиж, Түфа Лилүгү (突发利鹿孤 tufa lilugu)-д дагаар оржээ. 400 оны 8 сард Ганьгүй өмнөд Лян улсаас зугтан гарч, Чан Ань (长安 chang an)-д очин, Хойд Цинь улсад буун өгсөн байна. Хойд Цинь улс түүнийг баяртай хүлээн авч Юаньчуаньд буцаан суулган, түүний өөрийнх нь аймаг олныг захируулжээ.³

Зин улсын Юаньшигийн тэргүүн он буюу 402 оны 8 сард Умард Вэй (Тоба Вэй) улстай хийсэн Цайби (Фэншүй голын зүүн эрэг)-ийн их тулалдаанд Яо Син ихээр ялагдан хоёр түм гаруй цэргээ олзлуулан хүчин чадал нь суларсан үед дотоодод нь бослого тэмцэл гарч, зарим томоохон жанжин ноёдууд нь улсаас урван, тэр ч байтугай, бие даан тусгаарлах болжээ. Хойд Цинь улсын дотоод гадаад байдал хүндэрсэн энэ цаг үеийг ашиглан, Зүүн Зин улсын Иси (义熙 yixi)-гийн тавдугаар он буюу 409 онд Ганьгүй, түүний хүү Чифань нар цэрэглэн босож, 7 сард Ганьгүй өөрийгөө Цинь ван (秦王 qin wang)-д өргөмжилж, оны цолоо Гэнши (更始 gengshi) хэмээн нэрлэж, Баруун Цинь улсыг сэргээн тогтоожээ.⁴

Цифү Ганьгүй төр улсаа сэргээн тогтоосны дараа Хойд Цинь улс руу хэд хэдэн удаа довтолж, нэлээд хэмжээний газар нутгийг эзлэн авсан бөгөөд 409-412 оны хооронд Хойд Цинь, Өмнөд Лян, Тогон улсуудтай хийсэн дайнаар газар нутгаа өргөтгөн, зүүнш Пинсян (одоогийн Ганьсу мужийн Түнвэй сяний баруун өмнө), Люэян (одоогийн Ганьсу мужийн Циньань сяний зүүн өмнө), баруунш Зиньчэн, Байду (одоогийн Хөхнуурын Лэду сяний өмнө), өмнө зүг Дэнчэн (одоогийн Ганьсу мужийн Миньсяний баруун), Чишүй, умар зүг Дузянь шанаас хойш хүртэл өргөтгөжээ.⁵

Иси (义熙 yixi)-ийн 8 дугаар он буюу 412 онд Чипань (炽磐 chipan) эцгээ залгамжлан их сууринд сууж, оны цолоо Юнкан (永康 yongkang) хэмээв. Түүхэнд тэмдэглэснээр Чипань нь "Эрэлхэг баатарлаг, эрс шулуун зантай, хэрэг

¹ Лин Ган. Дунхугийн түүх. 239 дэх тал

² 晋书(jin shu).卷125, 乞伏乾归. 中华书局. 1999. 第2095页.

³ 晋书. 卷125. 乞伏乾归. 中华书局. 1999.

⁴ Зин шү-гийн "Цифү Ганьгүйн намтар"-т 3 дугаар он гэж байгаа ч, зохиолын тайлбарт 5 дугаар он болохыг залруулсан байна. Зохиолын 2108 дахь талыг үзнэ үү.

⁵ 晋书(jin shu).卷125, 乞伏乾归. 中华书局. 1999. 第2095页.

⁶ Лин Ган. Дунхугийн түүх. 251 дэх тал

⁷ Зин шү-гийн "Цифү Ганьгүйн намтар"-т 6 дугаар он гэж байгаа ч, зохиолын тайлбарт 8 дугаар он болохыг залруулсан байна. Зохиолын 2108 дахь талыг үзнэ үү.

шийдэхдээ цэгц мэргэн, арга ухаан нь бусдаас хэтийдсэн"¹ нэгэн байжээ. Тэрээр хаан болмогцоо юуны өмнө дайсагнагч хүчнүүдийг даран устгах бодлого явуулж, өөрийн байр суурийг бэхжүүлсэний дараа Хойд Цинь улсыг эсэргүүцэх тэмцлээ эхэлжээ. Чипань Өмнөд Лян улсад олон жил дараалан ган болж, дотоод байдал тогтворгүй байгааг ашиглан Юнкан (永康 yongkang)-ын гуравдугаар он буюу 414 оны 5 сард өөрийн биеэр цэргээ удирдан Өмнөд Лян улсыг довтолж, нийслэл Лэду (乐都 ledu) хотыг эзлэн Өмнөд Лян улс (Түфа сяньби нарын байгуулсан улс)-ыг мөхөөн өөртөө нэгтгэн авсан байна.²

Зянхунгийн 7 дугаар он буюу 426 онд Умард Лян улстай байлдаж байхад нь Ся улсын хаан Хэлянь Чан нийслэл Баохань-ийг гэнэдүүлэн довтолход Чипань арга буюу Динлянь (одоогийн Ганьсугийн Линься хотын зүүн өмнө)-д нийслэлээ шилжүүлжээ. Ся улсын цэрэг улам бүр түрэн Наньань, Юаньчуань хоёр тойргийг эзлэн авч, Баохань, Хуанхэ болон Сипинийг бүслэн хоёр түм илүү өрхийг булаан авчээ. Ийм үед Уши (одоогийн Ганьсугийн Линьдао сянь), Даоян (одоогийн Ганьсугийн Линьтань сяний хойно)-ы өмнө ууланд суурьшдаг уулын цян нар Баруун Цинь улсын ноёрхлыг эсэргүүцэн бослого гаргав. Улс орны байдал эгзэгтэй хүнд байсан 428 онд Цифү Чипань нас барж, түүний хүү Мумо (慕末 mumo) залгамжилжээ. 429 онд Хэси, Хуанхэ зэрэг газрыг Умард Лян улс эзлэн авч, Баруун Цинь улсын зарим жанжид буун өгчээ. 431 онд Ся улсын хаан Хэлянь Дин Баруун Цинь улсыг дахин довтолж, Мумо алагдан, Баруун Цинь улс мөхжээ.³ Ийнхүү Цифү Сяньби аймгуудын байгуулсан Баруун Цинь улс (385-431 он) мөхсөн боловч, Цифү сяньби аймгууд умард хятадын улс төр, угсаа соёлын хөгжилд нөлөө үзүүлсээр байжээ.

Муюн. Муюн бол Сяньбийн нэг аймаг бөгөөд тэдний тэргүүн Муюн нь Таньшихуайн байгуулсан улсын төвийн хэсгийн ахмадын тушаалыг хариуцаж байсан юм. Цао Цаогийн Вэй (220-265 он) улсын эхэн үед Муюн аймгийн тэргүүн Мохоба аймаг олноон дагуулан зүүн өмнө зүг нүүдэллэн Ляосид очиж, одоогийн Ляонингийн Зиньжоу хотын ойролцоо суурьшжээ. Мохобагийн гуравдугаар үеийн Шэгүйн үед Ляодунгийн хойно нүүн очжээ.⁴ "Вэй шү"-ийн 101 дүгээр бүлэг "Түгүхүний шастир"-т "Түгүхүн бол Түхэ (徒河 tuhe) голд нутагладаг Ляодунгийн Сяньбийн Шэгүй (涉归 shegui)-н хөвгүүн юм. Шэгүйн өөр нэрийг Илохань гэдэг. Хоёр хүүтэй. Татвар эмээс төрсөн ахмад хүүг Түгүхүн хэмээх бөгөөд бага хүүг нь Жологуй (若洛鬼 rouluogui) гэнэ. Шэгүйг нас барсаны дараа хүү Жологуй залгамжилж, Муюн (慕容 murong) хэмээх тусгай овог үүсгэжээ"⁵ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Зинь улсын Тайканы тавдугаар он (284 он)-д Шэгүй нас барж, Муюн Вэй залгамжилсан бөгөөд Зүүн Зинь улсын Сяньхэ-ийн наймдугаар он буюу 333 онд Муюн Вэй үхэж, хүү Муюн Хуан залгамжилжээ. Муюн Хуан эртнээс дайсагналцан байсан Сяньби угсааны Дуань, Юйвэн аймгуудыг нэгтгэн авч, 377 онд өөрийгөө Янь улсын ван хэмээн өргөмжлөөд (түүхэнд Түрүү Янь улс гэдэг), Лючэнийн хойно, Луншаны баруунтай Лунчэн хот (одоогийн Ляонинийн Чаоян хотод туурь нь буй)-ыг байгуулан нийслэлээ болгожээ.⁶ Зүүн Зинь улсын

¹ 晋书(jin shu). 卷125, 乞伏炽磐. 中华书局. 1999. 第2099页.

² 晋书(jin shu). 卷125, 乞伏炽磐. 中华书局. 1999. 第2100页.

³ 林 甘. дунхугийн түүх. 254-256 дахь тал

⁴ 林 甘. дунхугийн түүх. 149-150 дэх тал.

⁵ Жологуй- Зинь шү. 97 дугаар бүлэг. "Тогоны шастир"-т Муюн Гүй хэмээжээ.

⁶ 魏书(wei shu). 卷101. 吐谷浑. 第2233页

⁷ 晋书(jin shu). 卷109.

Юнхэгийн зургаадугаар онд Муюн Хуаны хөвгүүн Муюн Зюн хойд Жао улсын Зю хот (одоогийн Бээжин хот)-ыг эзэлж нийслэлээ шилжүүлсэн төдийгүй, Юнхэгийн наймдугаар онд Жао улсын нийслэл Е хотыг (одоогийн Хэнань мужийн Линьжан хотоос баруун өмнө 40 ли зайд байсан) эзэлж нийслэлээ болгон, ард олныг нь өөртөө нэгтгэн авчээ¹. Зүүн Зинь улсын Тайхэгийн тавдугаар он буюу 370 онд Е хот нь Цин улсын Фүзяньд эзлэгдсэнээр Түрүү Янь улс мөхжээ.

Муюн Гүй өөрийн ахтайгаа адуунаас болж муудалцан, ах Тогон нь баруун зүг нүүн одсонд өөрийгөө буруушаан, ахыгаа дурсан санаж "агань жи гэ" (阿干之歌 aganzhige) буюу "ахын дуу"-г зохион дуулсан² гэж "Зинь шү"-ийн 97 дугаар бүлэг "Тогоны шастир" болон "Вэй шү"-ийн 101 дүээр бүлэг "тогоны шастир", "Сун шү"-ийн 96 дугаар бүлэг "тогоны шастир"-т тус тус өгүүлжээ. "Сяньбийгаар ахыг агань (阿干 agan) гэдэг, тиймээс Түгүхүн ахыгаа дурсан санаж, [Муюн] Гүй (傀 gui) "ахын дуу" ("агань жи гэ" 阿干之歌 aganzhige)-г зохион, амьдралынхаа сүүлийн жилүүдэд ихэд гуниглан энэхүү дууг байнга дуулдаг байсан"³ хэмээн сурвалжид тэмдэглэсний "агань" (Сяньбигаар ах гэсэн үг) гэдэг "ах-а" гэсэн монгол үг хэмээн судлаачид санал нэгтэй тэмдэглэсэн байдаг. Хятад сурвалжуудын мэдээ баримтууд сяньбийн Муюн аймгаас Түгүхүн буюу Тогон аймаг салбарлан гарсаныг баталж байна.

Сяньбийн угсааны Муюн нар нь Түрүү Янь улс (337-370), Хожуу Янь улс (384-409), Баруун Янь улс (386-394), Өмнөд Янь (398-410)-уудыг үндэслэн байгуулж, умард Хятадад ноёрхож байжээ.

Түгүхүн. (吐谷浑tuguhun). Түгүхүн буюу Тогон бол Муюн Сяньбийн нэг салаа бөгөөд өвөг дээдэс нь Ляодунд нутаглан сууж, сүүлд нь умар зүг нүүн Ляоси голын баруун дахь Түхэ (одоогийн Ляонин мужийн Исянь)-ийн Циншаньд нутаглан сууснаас түүх сударт тэднийг Ляонингийн Сяньби буюу Ляосигийн сяньби гэж тэмдэглэсэн байна.⁴

"Вэй шү"-ийн 101 дүгээр бүлэг "Түгүхүний шастир"-т "Түгүхүн бол Түхэ (徒河tuhe) голд нутагладаг Ляодунгийн Сяньбийн Шэгүй (涉歸shogui)-н хөвгүүн юм. Шэгүйн өөр нэрийг Илохань гэдэг. Хоёр хүүтэй. Татвар эмээс төрсөн ахмад хүүг Түгүхүн хэмээх бөгөөд бага хүүг нь Жологуй (若洛鬼rouluogui) гэнэ. Шэгүйг нас барсаны дараа хүү Жологуй залгамжилж, Муюн (慕容murong) хэмээх тусгай овгийг үүсгэжээ."⁵ хэмээн тэмдэглэсэн байна.

Хятад сурвалжид тэмдэглэгдсэн түүхэн домог ёсоор, Муюн Шэгүй (涉歸shogui) хаан хоёр хүүтэй байжээ. Ахмад хөвгүүн Түгүхүн (吐谷浑) нь татвар эмээс төрсөн ба Шэгүйн авааль хатнаас Муюн Гүй (慕容傀 muronggui) (зарим сурвалжийн мэдээгээр Жологуй) төржээ. Тиймээс Муюн Гүй эцгийгээ залгамжилж хаан болсон байна. Эцэг нь амьд ахуй цагтаа Түгүхүнд 1700 муюн сяньби өрх айлыг газар нутгийн хамт эзэмшил болгон олгожээ. Нэгэн удаа тэдний адуу урцалдан зодолдож, бие биенийгээ сүрхий гэмтээжээ. Муюн Гүй ихэд уурсаж, ахыгаа чи эртхэн холдож өөр газар очоогүйгээс болж адуунууд нэг нэгнийгээ бэртээхэд хүрлээ гэж зэмлэн хөөжээ. Ах нь ихэд гомдож, өөрийн харьяат аймгаа дагуулан алс баруун зүг зайлан нүүжээ. Дүү нь ахыгаа хөөн

¹ Материалы по истории кочевых народов в Китае. III-V вв. Вып. 1, Сюнну. Пер. С кит. предл. и комм. В.С.Таскина. М., 1989. с 171.

² 晋书(jin shu), 卷 97, 吐谷浑. 中华书局. 1999. 第1693页

³ 晋书(jin shu), 卷 97, 吐谷浑. 中华书局. 1999. 第1693页

⁴ 吐谷浑tuguhun-ийг Н.Я.Бичурин, Г.Сүхбаатар, Лин Ган нарыг баримтлан "Тогон" хэмээв.

⁵ Лин Ган. Дунхугийн түүх. 283 дахь тал

⁵ 魏書 (Wei shu), 卷 101, 吐谷浑. 第2233頁

явуулсандаа ихэд харамсан буцаан авчируулахаар араас нь элч илгээсэн боловч Түгүхүн элчийн ятгалганд автсангүй, цаашид нүүн одсон¹ ажээ. Ляодун хавийн нутгаас III зууны сүүлчээр Түгүхүн аймаг олноон дагуулан баруун зүг нүүдэллэж, Мони ууланд очин сууршиж, IV зууны эхэнд дахин барууншилж Таохэ гол (Ганьсу, Хөхнуур хоёр мужийн хил дэх Сициншан уулын зүүн бэлээс эх авсан Хатан голын зүүн биеийн цутгалан)-ыг гаталж, Шилин (одоогийн Хөхнуурын Синин хот орчим), Ганьсун (эдүгээгийн Хөхнуурын зүүн өмнө хэсэг)-ээс баруунших газрыг эзэмшиж, Байлин (одоогийн Хөхнуурын Цайдамын хотгор дахь Дулаан сянь орчим)-ын хэдэн мянган газрын дотор цянчуудтай холилдон суув.² Тогон нь Хөх нуурт очсон Сяньби аймаг мөн бөгөөд аймгийнхаа толгойлогчийн нэрээр түгүхүн буюу Тогон хэмээн нэршсэн ажээ. Тэд Хөх нуурт Тогон улс (IV-VII зуун)-ыг байгуулан оршин тогтнож байсан.

П.Пеллио, Ф.Томас нарын судалгаагаар VII-VIII зууны үеийн төвд сурвалж бичигт Тогон, Сүмбэ гэх хоёр нэрээр тэмдэглэгдэж байсан бөгөөд Тогон улс V зууны үед тангадын угсааны цян нарыг удтал эрхшээлдээ оруулсан. Төвдүүд 663 онд Тогон улсыг мөхөөхөд Тогоны хаан Мага Тогон (Maga Toghon) төвдийн язгууртнуудтай нийлэн их сайд гэдгээс дээгүүр цолтой тушаалтан болсон³ ажээ.

Лигети Дунхугийн угсааны аймгуудыг түүхэн хэл шинжлэлийн үүднээс судалж үзээд, "тэднээс (Сяньби нараас.П.Д) нэг талаар си болон хятанчууд, нөгөө талаар нилээд хожим а-жа нарын бүлэг салбарлан гарчээ. А-жааг хятадаар ту-юй-хунь, төвдөөр ha – жа гэж нэрлэнэ"⁴ гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Күмоси (庫莫奚 Kumoxi). Күмосигийн нөгөө нэг нэрийтэл нь Татаби гэдэг.

Хятад сурвалжуудад Си (奚 xi) хэмээх нэрээр тэмдэглэгдсэн нь ч байдаг. Күмоси нар нь Хятантай хамт одоогийн өвөр Монголын зүүн хэсгийн нутаг, Ляонин мужийн баруунтайгаар Хэбэй мужийн Чэндэ хотын хойгуур нутаглаж байжээ. Умард Вэй улсын Дэнго-ын хоёрдугаар он (388)-д Дао Уди хаан (табгачи Гүй)-д цохигдон, аймаг олон нь бутарсанаас Хятанаас салж, бие даах болсон байна. Сүй болон Тан улсын үед Күмоси аймгууд Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд орж, руни бичгийн дурсгалуудад Татаби хэмээх нэрээр тэмдэглэгджээ. Күмоси аймгууд Тан болон Түрэг хоёр хүчирхэг улсын эсрэг хүчин мөхөсдөж байсан тул нэг үе Түрэг улстай, нөгөө үе Тан улстай нэгдэн байв.

Тан улс Күмосийн дээд давхаргыг "элбэн мэхлэх" бодлого явуулж, гүнжээ Күмоси ванд өгөн ураг барилдан, "шижир алтан түмэн лан шагнаж" байсан ч Күмосичууд заримдаа дагаж, заримдаа урваж, Тан улс болон Түрэг улсын хооронд бөөрөнхийлж байсан⁵ хэмээн Лин Ган бичжээ. Энэ нь Күмоси нар урвамтгай, итгэлгүйгээс болсон биш, өөрсдийн бие даасан байдлаа хадгалахын тулд тухайн цаг үеийн цэрэг, улс төрийн нөхцөл байдалд зохицох бодлого явуулж байсантай холбоотой бололтой.

"Сүй улсын судар"-ын 84 дүгээр бүлэгт "Си (奚)-ийн анхны нэрийтэл нь Күмоси (庫莫奚) юм. Тэд Хугийн удам бөгөөд зүүн талд нь оршино"⁶, "Жоу улсын түүх"-ийн 49 дүгээр бүлэгт "Күмоси нь Сяньбийн тусгай салаа"⁷, "Шинэ Тан улсын судар"-ын 219 дүгээр бүлэгт "Си нь бас [хятантай адил] Дунхунд хамаарна"

¹ 晋书(jin shu). 卷97. 吐谷浑. 第1693页.

² 晋书(jin shu). 卷97. 吐谷浑. 第1693页.

³ Сүхбаатар Г. Монгол Нирун улс. УБ., 1992. 192 дахь тал

⁴ Л.Лигети. Алтай хэлний удиртгал. 333 aadu oae

⁵ Лин Ган. Дунхугийн түүх. 364 дэх тал.

⁶ 隋書(shui shu). 卷 84. 奚. 中華書局出版. 第一版. 1973. 第1881 頁

⁷ Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. М., 1984. с.144.

хэмээсэн бол, “Хуучин Тан улсын судар”-ын 199 дүгээр бүлэг бүлэг болон “Таван улсын түүх”-ийн 74 дүгээр бүлэгт “Сичүүд нь Хүннүгийн тусгай салаа”¹ гэж тэмдэглэжээ.

Хятанчууд Күмоси нарыг өөртөө нэгтгэн авч, тэднийг Таван аймагт хувааснаар “Таван аймаг Күмоси” хэмээх нэр түүх сударт тэмдэглэгдэх болсон бөгөөд Тайзу хаан (Елюй Абужи)-ы Тянь Цаны гуравдугаар он буюу 923 онд нэг аймаг нэмэгдэн “таван хороо зургаан аймаг” болжээ.

Хожим нь “күмоси буюу си нарын нэр түүхэнд үзэгдэхгүй үе нь урианхай нарын нэр түүхэнд анх гарч ирсэн үе хоёр ерөнхийдөө ойролцоо байна. Энэ нь урианхай нар бол күмоси нарын залгамж хойч үе гэсэн сурвалж бичгийн мэдээтэй авцалдах төлөвтэй байна”² гэж зарим судлаачид үздэг бол зарим нь кимак нарыг күмосичуудаас гаралтай гэдэг.

Жоужань (柔然 ruoran). “Вэй шү”-ийн 103 бүлэг “жуаньжуаны шаштир”-т “Жуаньжуань бол дунхугийн удам (苗裔 miaoyi) мөн, юйзюлюй (郁久閼 yujiulь) овогтой. Анх Шэньюаний сүүлчээр (табгачийн) тонуул морьт цэргүүд үс нь хөмсгөө хүртэл ургасан бөгөөд уг овог, нэрээ мартсан нэгэн боолыг барьжээ. Түүнийг эзэн нь Мугулюй (木骨閼 mugulь) гэж нэрлэжээ. Мугулюй нь мухар толгойт гэсэн үг юм. Мугулюй, юйзюлюй хоорондоо дуудлага ойролцоо, иймд үр ач нар нь мугулюйг овог болгосон байна. Мугулюй эрийн цээнд хүрээд боолоос чөлөөлөгдөн морин цэрэг болжээ. Муди хаан (Илу хаан 304-316) хааны үед дайчилгааны товоос хожимдон цаазаар авахуулах болохоор зугтаж, уудам говийн хавцалд нуугдан, зугтаагчдыг цуглуулж, зуу гаруй хүн болоод хэтулинд (紇突鄰 hetulin) аймгийг түшиглэжээ. Мугулюй үхсэнээс хойш хүү Чарагуй нь эрэлхэг дайчин байсан болохоор аймаг олонтой болж эхлээд, өөрсдийгөө Жоужань (柔然 rouan) хэмээн нэрлэжээ. Вэй улсад алба барьж байв. Хожим Шизу (Даохаан 424-452) тэд мэдлэггүй, мунхаг бөгөөд байдал нь тарианы өттэй төстэй учир жуаньжуань (.....ruanruan) гэж өөрчлөн нэрлэжээ”³ гэжээ. Сурвалжийн дээрх мэдээнээс үзэхэд, Чаругуйн анх өгсөн Жоужань (柔然 rouan) нэмээх улсын нэр нь зэрэг утгатай байсан нь мэдээж бөгөөд харин Шизу хаан дуудлага ойролцоо жуаньжуань (.....ruanruan) ханз үсгийг хэрэглэн доромжилсон утгатай болгожээ гэдгийн Н.Я.Бичурин, В.С.Таскин, П.Пеллио, Г.Сүхбаатар нарын зэрэг эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Үүнээс гадна Жоужанийг “Зинь шү”-ийн 125 дугаар бүлэгт жоужуань, “Жоу шү”-д жужу гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд жоужань, жуаньжуань, жуйжуй, жужу гэсэн нэрс цөм жоужань гэдэг нэрийн сунжирсан хэлбэр мөн гэж эрдэмтэд санал нэгтэй үзсээр байгаа билээ.⁴

Жоужань хэмээх нэрийг тайлбарласан эрдэмтдийн олон янзын тайлбар байдаг. Сүрбадрах Жоужань гэдэг нь цаньлань гэдгээс, цаньлань нь дянъянь-аас үүсэлтэй. Дянъянь нь динлин мөн. Динлин нь дили мөн бөгөөд ди гэдэг нь хамгийн эрхэм, тэнгэрийн сахиулсан гэсэн үг хэмээгээд жоужань бол улсын цол болохоос биш, угсаа үндэсний нэрийтэл биш юм гэжээ.⁵ Ц.Хандсүрэн Жоужань нь “зузаан” гэсэн монгол үг гэж үзжээ.

Т.Фузида “ёсон” гэсэн үг хэмээсэн бол, К.Широтори “цэцэн” хэмээх үг гэж үзжээ. Г.Учида Жоужань, Авар хоёрыг нэг нэр мөн гэж үзсэн. Г.Сүхбаатар эдгээр

¹ Таскин В.С. М., 1984. с.144,152

² Очир А. Урианхай нарын угсаа-түүхийн асуудалд. // ТС. Т.ХХХII, Ү. 2, УБ., 2000. 22 дахь тал

³ 魏書 wei shu. 卷103.柔然. 第2289頁, Сүхбаатар Г. Монгол нирун улс.УБ.,1992. 165 дахь тал

⁴ Сүхбаатар Г. Монгол нирун улс. УБ., 1992. 165 дахь тал.

⁵ Сүрбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин. 1988. т.62.

эрдэмтэдийн дэвшүүлсэн саналууд учир дутагдалтай болохыг шүүмжлээд "Жоужань гэдэг нэрийг хэл шинжлэл, түүх, угсаатан зүй зэрэг тал талаас нь нягтлахад язгуур монголчуудын угсаатны нэгэн өрөнхий нэр болох нирун гэсэн нэр мөн байна"¹ гэжээ. Г.Сүхбаатар Жоужанийг монгол гаралтай гэдгийг олон талаас нь батлан нотолж, "нирунчууд бол язгуур монголчууд мөн" гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Үнэхээр Жоужаньчууд нь Дунхугийн удам бөгөөд монгол угсааны аймгууд байсан нь хятад сурвалжийн мэдээ баримт болон эрдэмтдийн судалгаагаар нотлогдож байна.

Жоужаний дээд өвөг Мугулюй (木骨閭 muguly) хэмээх нэрээс "монгол" гэх угсаатны нэр үүссэн хэмээн нэлээд судлаачид үзэж байна. Мугулюй буюу монгол гэдэг нэртэй Жоужаний ноёлох овог байсан бөгөөд Түрэгүүдэд цохигдон Жоужаний хаант улс мөхөхөд Монгол овог удирдуулсан Жоужаний зарим хэсэг нутаг орноосоо дайжин нүүсэн бололтой бөгөөд Эргэнэ гүн-ийн домгоор дамжуулан тэднийг түүх сударт тэмдэглэжээ.

"Сун шү"-ийн 95 дугаар бүлэгт "Гээзэгтэн боолууд табгач нар Хятад улсыг эзэлсэнээс хойш жуйжуй боолууд тэдний хуучин нутгийг эзлэн авсан. Тэр нутагт Хан улсын үеийн Хүннүгийн умард ордон байдаг. Жуйжуйн нэг нэр нь датань, бас таньтань гэдэг, мөн хүннүгийн өөр аймаг юм" гэжээ. Жоужаний өөр нэрийтэл хэмээн сурвалжид дурдагдаж буй "датань", "таньтань" хэмээх нэр нь Датань хааны нэрээс үүсэлтэй "Татар" хэмээх нэр мөн гэдгийг эдүгээ судлаачид нэгэнт хүлээн зөвшөөрөх болжээ. Ийнхүү монгол болон татар хэмээх монгол угсаатны нэрийдэл Жоужанаас үүсэлтэй байгаа нь тэд монгол угсааны аймгууд байсныг нотлох нэгэн баримт гэж судлаачид үзэх болжээ.

Хятан. Хятан аймгууд Ляо улс (916-1125)-ыг үндэслэж, умард хятад болон Төв Азийн нүүдэлчдийг нэгтгэсэн эзэнт гүрэн байгуулсан билээ.

"Ляо улсын түүх"-ийн 63-р бүлэг "Үе удмын илтгэл"-д Дунхугийн нэгэн аймгийн тэргүүн "... Гэүтү (葛乌菟 gewutu) хэмээгч үе улиран говь хязгаарыг эзэмшин байсан бөгөөд Маодунь хаан (冒顿可汗 maodun kehan)-д цохигдон, Сяньби ууланд зугтан очиж, Сяньби овогтон болов. Хожим бас муюн нарын Янь улсад дийлдэн, аймаг угсаа нь бутарсанаар Юйвэнь (宇文文wen), Күмоси (库莫奚 kumoxi), Хятан (契丹 qidan) хэмээн салжээ. Хятанчуудын нэрийтэл үүнээс эхэлжээ" хэмээхийн хамт, мөн "Сяньбийн Гэүтү (鲜卑葛乌菟 xianbei gewutu)-ийн хойчис Пүхүй (普回 puhui), Пүхүйгийн хөвгүүн Мона (莫那 mona) нь Иньшань (阴山 yinshan) уулаас өмнөш нүүн, Ляосид очин суужээ. Есдүгээр үе нь Муюнхуай (慕容晃 muronghuang)-д ялагдаж, Сяньби олон сарниж Юйвэньжи (宇文氏 yuwenzhi), Күмоси (库莫奚 kumoxi), Хятан (契丹 qidan) нар салбарлажээ"² хэмээх зэргээр Хятад сурвалжуудад Юйвэнь, Күмоси, Хятан нарыг Дунхугийн удам хойчис төдийгүй Сяньбигаас гаралтай болохыг тодорхой өгүүлсэн нь олонтоо. "Вэй шү"-ийн 100-р боть "Хятаны шастир"-т "Хятан нь удам гарвал нэгт Күмосигийн зүүн талд оршино"³ гэж тэмдэглэжээ.

Хятадын эрдэмтэн Лин Ган "Вэй шү", "Умард төрийн түүх"-ийн мэдээнд үндэслэн Хятан нар уул нь Күмоси, Юйвэнь хоёр овогтой хамт нүүдэллэн малжиж байв. МЭ 344 онд Умард Янь улсын Муюнхуай Юйвэнь аймгийн тэргүүн Юдоугүйг дайлахад, Хятан нар ч цохигдон сарниснаас Сяньби нараас салбарлан гарч, өөрсдийгөө "Хятан" хэмээж, Хуаншүй гол (одоогийн Шармөрөн

¹ Сүхбаатар Г. 1992. 166-176 дахь тал

² 辽史(liao shi). 卷63. 世表. 中华书局. 1999. 第583. 585页.

³ 魏书. 卷100. 契丹. 第2223页

гол), жич Түхэ гол (одоогийн Луухын гол)-ын сав газраар нүүдэллэн малжих болжээ. Хятанчууд Сяо Вэнди хааны Тайхэгийн 3-р он буюу МЭ 479 онд умард Вэй улсад харьяалагдаж, Байланшүй гол (одоогийн Далинхэ гол) орчимд шилжин нутаглажээ¹ хэмээсэн бол, академич Х.Пэрлээ "Сяньби нар МЭ II зууны үед Ляохэ (одоогийн Луу-ха) голын хоёр талаар нутаглаж, Ляодүнгийн сяньби, Ляосийн Сяньби гэж нэрлэгддэг болжээ. МЭ IV зууны үед Ляосийн Сяньби нар, Ляодүнгийн сяньби нараас гарсан Мүюн-хуан гэдэг ноёнд ялагдаж бутран, Юй-вэнь, Күмоси, Хятан аймгууд болсон байна"² гэжээ. Ийнхүү судлаачид Хятан, Күмоси, Юйвэнийг Дунхугийн угсаа, тэдний хойчис гэдэгтэй үндсэндээ санал нэгдэж буй.

Дунхугийн угсааны аймгуудын хэлийг судалсан эрдэмтэд түүхэн хэл шинжлэлийн талаас тэдгээр нь монгол хэлтэн аймгууд байсныг баталсан. Л.Лигети "Тэднээс (Сяньби нараас.П.Д) нэг талаар си болон хятанчууд, нөгөө талаар нилээд хожим а-жа нарын бүлэг салбарлан гарчээ" хэмээгээд "Онолын үүднээс бол энэ тухайд ч гэсэн тэр үед монгол хэл нэгдмэл байсан гэж бодохуйяа бэрх юм. Наанадаж ши-вэй, хятан хийгээд ту-юй-хунь буюу а-жа гэсэн монгол хэлний гурван төв байсныг бид харгалзан үзэх ёстой"³ гэсэн байна. Л.Лигети Хятан хэлийг судлаад "Хятаны тулгар бичгээс хятан үгс зуу гаруйг төдөлгүй олж болно. Түүний ихэнхийг онцын бэрхшээлгүй тайлан уншиж болох бөгөөд хятан хэл монгол хэлэнд хамаарагдах нь маргаангүйг эдгээр үгс гэрчилж байна. Энэ хэл XII-XIV зууны үеийн монгол хэлийг бодвол нэлээд эртний шинжтэйг (үгийн эхэнд "h"-ийн оронд басхүү "p" байсаар байдаг) тогтоож болно. Үүнээс гадна энэ хэл нь зарим нэгэн ноцтой онцлог бүхий бөгөөд нэлээд их тагнайшсан нутгийн аялгуу болох юм. Үүнд: jau, taw, towus, nair, sair (jayun (зуу), tabun (тав), toyusun (тоос), naran (нар), saran (сар) гэдэгтэй тохирох) гэх мэт хэдэн хятан үгийг дурдая"⁴ хэмээсэн байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол нутаг дахь эртний улсууд нь нүүдэлчдийн нийгмийн бүтцийн онцлогоос үүдэн сигментари бүтэцтэй байжээ. Өөрөөр хэлбэл, угсаа соёлын хувьд ойролцоо хэд хэдэн аймгууд нэгдэн ханлиг (аймгийн нэгдэл) болдог бөгөөд нүүдэлчдийн эзэнт гүрнүүд нь холбооны маягийн бүтэцтэй, бие даасан олон аймгуудын нэгдлээс бүрэлддэг байсан байна. Эзэнт гүрний бүрэлдэхүүнд орж байсан эдгээр аймгийн нэгдлүүд (аймгийн холбоо, chiefdom, ханлиг) нь хэл, угсаа соёлын хувьд янз бүр (монгол, түрэг, хамниган)-ийн аймгууд байсан төдийгүй аль хүчирхэг аймгийн нэгдлийн манлайлал дор нэгдэн, тэдний ноёрхлыг хүлээн зөвшөөрдөг байжээ. Үндсэндээ дагаар орсон аймгууд бүтцээ хэвээр хадгалан үлддэг байсан нь түүхэн үйл явцаас харагдаж байна. Эзэнт гүрний бүрэлдэхүүнд орсон аймгийн нэгдлүүд татвар төлдөг, харин "хугацаа нь хэтэрвэл охид бүсгүйчүүдийг нь булаан авч, боол, шивэгчин болгодог" байсан нь сурвалжид тэмдэглэгдэн үлджээ. Аймгуудын нэгдлийг тухайн аймгуудын толгойлогч захирдаг, тэдгээр нь баруун, зүүн, төвийн түмний аль нэгэнд хамаарагдан захирагддаг байсан бололтой. Хэдийгээр Хүннүгийн үед аравтын систем тогтож байсан ч, энэ нь цаашид тууштай хэрэглэгдэж байгаагүй бололтой. Ямартай ч, овог, аймгийн системийг эвдэж чадсангүй. Үүнийг Хүннүгийн бүрэлдэхүүнд багтаж байсан Сяньби, Ухуань, Усунь зэрэг аймгуудын түүхээс харж болох юм.

Ийнхүү аймгуудын нэгдэл нь харьцангуй бүхэллэг, нэгдмэл байдлаа хадгалж байсан нь угсаатан бүрэлдэх үйл явцад сөргөөр нөлөөлж байсан

¹ Лин Ган. Дурдсан зохиол. 17 дахь тал,

² Пэрлээ Х. Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь. УБ., 1959. 9 дэх тал

³ Л.Лигети. Алтай хэл шинжлэлийн удиртгал. 335 ааdū dāe

⁴ Л.Лигети. Алтай хэл шинжлэлийн удиртгал. 333 ааdū dāe

төдийгүй улс төрийн нэгдмэл байдлаа хадгалж, том эзэнт гүрэн оршин тогтнох үндсийг хэврэгшүүлж байжээ. Аймгуудын нэгдлүүд (аймгийн холбоо, chiefdom, ханлиг)-ын хүн ам нь өсөж, цэрэг-улс төрийн талаар бэхжихийн хамт тусгаарлахын төлөө, улмаар бусдыгаа эзлэн ноёрхохын төлөө тэмцэж эхэлдэг байна. Эзэнт гүрний хүч суларч, доройтоход бусад нь хүлээн зөвшөөрөхүйц хүчирхэг аймгийн нэгдэл байхгүй үед эдгээр аймгийн нэгдлүүд бие даасан ханлиг, улсууд болон задардаг байжээ.

Хүннүгийн бүрэлдэхүүнд багтаж байсан Сяньбийн аймгуудын хүн ам өсөж, шинэ шинэ аймгууд салбарлан гарсан бололтой. Ямар ч гэсэн, МЭ I зууны сүүл, II зууны эхэн үе гэхэд Сяньбийн бие даасан тусгаар олон аймгууд (аймгуудын нэгдэл) оршин байсан байна. Сяньбийн аймгуудын эдгээр нэгдлүүд нь харьцангуй бүхэллэг, цэрэг-улс төрийн талаар нэгдмэл байжээ. Сяньбийн аймгууд Хүннүгийн газар нутгийг эзэлсний дараа Таньшихуай (檀石槐 tanshihuai) нийт Сяньби аймгуудыг нэгтгэн, Хүннүгийн хуучин эзэмшиж байсан нутгийг бүхэлд нь хяналтандаа авсан бөгөөд сурвалжийн мэдээг үндэслэвэл, зүүнээс баруун зүг хүртэл 14000 ли газрыг нэгдсэн удирдлагад оруулж чаджээ. Таньшихуай Хүннүгийн адил улсаа зүүн, баруун гар, төв гэсэн гурван хэсэгт хуваан захирч байсан талаар "Хоу Хань шү"-д Таньшихуай "өөрөө нутгаа гурван хэсэг хуваасан, үүнд, Юбэйпин (右北平 youbeiping)-ээс зүүн тийш Ляодун (辽东 liaodong)-ийн Пуё (Фуюй) 夫..., Вэймо (葸貉 weimo) хүртэлх 20 гаруй аймгийг (И) зүүн хэсэгт, Юбэйпин (右北平 youbeiping)-ээс баруун тийш Шангу (上谷 shang gu) хүртэлх 10 гаруй аймгийг төв хэсэг, Шангу (上谷 shang gu)-гаас баруун тийш Дуньхуань (敦煌 dunhuang) хүртэлх 20 гаруй аймгийг баруун хэсэг болгон, тус бүрд нь толгойлогч (大人 daren) томилон захируулсан, цөм Таньшихуай (檀石槐 tanshihuai)-д захирагдана"¹ гэжээ.

Гэвч Таньшихуай үхсэний дараа Сяньбийн аймгийн нэгдлүүд биеэ даах болжээ. Улмаар Сяньбийн аймгууд хойд хятад руу шилжин суурших болж, өөрсдийн төр улсуудыг байгуулан ноёрхох болсон. Кэбинэн Сяньбийн бие даасан аймгийн нэгдлүүдийг нэгтгэхийг оролдсон боловч зөвхөн говийн өмнөх Сяньби аймгуудыг түр нэгтгэж чадсан байна. Сяньби гүрэн удаан оршин тогтноогүй ч, Сяньбийн аймгууд тус тусдаа олон төр улсуудыг байгуулж, хойд Хятадад олон зуун жил оршин тогтнож байсан билээ. Ийнхүү сяньби угсааны бие даасан олон улсууд орших болсоноор Монгол хэлт Сяньби угсааны угсаатны олон бүлгүүд үүсэх нөхцлийг бүрдүүлжээ. Гэвч цагаан хэрмээс урагш нүүн очиж, өөрсдийн төр улсыг байгуулан, хойд Хятадад ноёрхож байсан Сяньби аймгуудын ноёрхол эцэс болоход тэдний ихэнх нь Хятадад үлдэж, хятадын соёлд ууссан бололтой. Өөрөөр хэлбэл, тэднээс уугуул нутагтаа буцаж ирсэн нь үлэмж бага бололтой бөгөөд монгол хэлт аймгуудын угсаа-соёлын цөм нь цагаан хэрмээс хойш нутаглаж байсан нүүдэлчин аймгууд болсон байна. Тэдгээрийн дотроос одоогийн Монгол улсын нутгаар үндсэндээ төвлөрөн оршиж байсан Жоужаний хаант улс нь монгол хэлт нүүдэлчдийн угсаа-соёлын нийтлэг бүрэлдэн тогтоход томоохон үүрэг гүйцэтгэжээ.

¹ 后汉书 (hou han shu). 卷90, 乌丸鲜卑. 乐天书局. 中华民国六十三年. 第2989-2990页

Abstract: Although the Sianbi empire did not exist for long, the Sianbi aimags established separate states that existed for many centuries on the Mongolian and Chinese territories. Existence of sianbi nations has set the foundation for emerging of numerous Mongolian-speaking groups of sianbi nationality. Most of sianbi aimags, which moved south of the White wall and established their states, settled in China after their fall and were overwhelmed by the influence of the Chinese culture. However, such aimags as Togon, Hyatan and Kumosi have preserved their traditional language, culture and statehood traditions, thus continuing to make valuable contribution to the development of Mongolian nationalities. Among these sianbi aimags the Joujan monarchy that mainly existed on territory of modern Mongolia has played the most significant role in formation of a Mongolian speaking nomadic ethnic group.

Ном зүй

1. 后汉书 (hou han shu). 乐天书局. 中华民国六十三年. 魏書 (Wei shu). 中華書局出版, 第二版, 1984.
2. 隋書 (shui shu). 中華書局出版. 第一版. 1973.
3. 晋书 (jin shu). 中华书局. 1999.
4. 辽史 (liao shi). 卷63. 世表. 中华书局. 1999.
5. 马长寿. 乌桓与鲜卑. 上海. 1962.
6. Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997
7. Викторова Л.Л. Монголы (Происхождение народа и истоки культуры). Москва, 1980
8. Ганболд Ж. III-IV зууны үеийн төв Азийн нүүдэлчдийн улс төрийн түүхийн асуудлууд //Археологийн судлал. Томус 13, УБ., 1992. 22-28
9. Грумм-Грижимайло. Г.Е. Западная Монголия и Урианхайский край. Том. II-Л., 1926.
10. Дэлгэржаргал П. Монголчуудын угсаа гарвалын түүхийг судлах онол арга зүйн зарим асуудал. -Түүхийн танин мэдэхүйн явц дахь мета онолын ба эмпирик асуудлууд-орчин үе. УБ., 2004. 58-74.
11. Бичурин. Н.Я. Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена. Том I, II, III. М.-Л., 1950
12. Лигети Л. Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь. Хэл зохиол судлал. Томус VII, Fasc 9, УБ., 1970.
13. Лигети Л., "Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков". //Хэл зохиол судлал. Том VIII. Fasc 11. УБ., 1970. 321-339
14. Л.Лигети. Алтай хэлний удиртгал. (англи хэлнээс орчуулсан В.Энхболд, Л.Жундаан). УБ., 1999
15. Лин Ган. Дунхугийн түүх. ӨМАХХ. 1997.
16. Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ., 2003
17. Очир А. Урианхай нарын угсаа-түүхийн асуудалд. // ТС. Т. XXXII, F. 2, УБ., 2000.
18. Пэрлээ Х. Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь. УБ., 1959
19. Сүрбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин. 1988.

20. Сүхбаатар Г. Хүннү, Сяньбийн хоорондын угсаа гарлын холбогдол.// ТС. Т.VIII, F. 4, УБ., 1969.
21. Сүхбаатар Г. Сяньби. УБ., 1971.
22. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980.
23. Сүхбаатар Г. Монгол Нирун улс. УБ., 1992.
24. Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Москва, 1984
25. Таскин В.С. Материалы по истории кочевых народов в Китае. III-V вв. Вып. 1, Сюнну. М., 1989.
26. Хандсүрэн Ц. Жужаны хаант улс. УБ., 1994